



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/287

Булган

Газар эзэмших эрх дуусгавар  
болгох тухай

Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5, 43 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны зүүн талд байршилтай иргэн Ц.Батжаргал, Г.Эрдэнэ, Д.Уламбаяр, А.Ганболд нарын эзэмшил нийт 741 м2 газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авч, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Дээрх нэр бүхий 4 иргэнтэй газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах гэрээ байгуулан, газар чөлөөлөлтөд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Булган сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Эзэмших эрх нь дуусгавар болсон газрыг 2018 оны 05 дугаар сарын 13-ны дотор чөлөөлж, аймгийн Засаг даргын мэдэлд шилжүүлэхийг нэр бүхий 4 иргэнд даалгасугай.

4. Газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авахад шаардагдах хөрөнгийн урьдчилгаа 5000000 /таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2009 оны 32 дугаар захирамжийн Ц.Батжаргал, Г.Эрдэнэ, Д.Уламбаяр, аймгийн Засаг даргын 2014 оны Б/77 дугаар захирамжийн А.Ганболд нартай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ